

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Энэ хуулийг дагаж мөрдөх өдрийг хүртэл Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 8, 9 дүгээр зүйлийг хэвээр мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон нийт тэтгэвэр авагчид баталгаат тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүртэл хугацаанд тооцон олгох бөгөөд баталгаат тэтгэврийн хэмжээ нь баталгаат тэтгэврийн суурь дүн (Бс)-тэй тэнцүү байна.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өдрөөс эхлэн баталгаат тэтгэвэр (Бт), баталгаат тэтгэврийн суурь дүн (Бс)-гийн зөрүүг олгоно.

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш тэтгэвэр тогтоолгосон бөгөөд өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр (Бт)-ийг олгоно.

5 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7.7, 7.8 дахь хэсгийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ